



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
ХАРЬЯА БУЛГАН АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР**

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Д.ЭРДЭНЭБАТ ТАНАА

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2016.04.25 № 74

Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15.1, Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн болон бусад тайлбар тодруулга бүхий нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийв.

Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүдээнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Санхүүгийн аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол

070000104

хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн орон нутгийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЛХАГВАЦЭНД